| 4.1.4. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байх. | | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, тайланг үнэн зөв гаргаж хүргүүлнэ. | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах боломжоор хангасан байна. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт тайлагнасан байна. | 2023 онд байдлаар Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль бусад тогтоомж шийдвэрийн хүрээнд хүний нөөц томилгоог батлагдсан төсөв орон тоонд багтаан шийдвэрлэж А тушаал 34, Б тушаал 95 гаргаж ажилласан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/39 дүгээр тушаалаар 2018 оны “Бүтэц орон тоо батлах тухай” А/22 дугаар тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж Сүлжээний инженер, Сан хариуцсан мэргэжилтэн, Магадлагч эмчийн албан тушаалыг ТҮ байж болохоор зохицуулалт хийж Аймаг дүүргийн Нийгмийн даатгалын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлтэсүүдэд албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан баталж мөрдөн ажиллах зөвшөөрөл олгосон.<br>Үүний дагуу Хэлтсийн даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/11 тоот тушаалаар дээрх албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулан мөрдөн ажиллаж байна. | |
| 4.1.5. | Хэлтсийн дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүрэг, ажлын байрны үндсэн зорилтыг давхардуулахгүй байх, ажлын байрны гол үйл ажиллагааг тодорхой болгох. | Хэлтсийн ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байна. 2022 онд 4 шинэлэг ажил үйлчилгээ хийж хэрэгжүүлсэн. | Хэлтсийн дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна. | Төсөл хөтөлбөр, инноваци, бүтээмжийн зөвлөлөөс байгууллагын үйл ажиллагааны алдаа дутагдлыг илэрүүлж, арилгах бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын нөхцөл байдал, ажлын ачаалал, байгууллагын соёлын сэтгэл ханамжтай байдал, ажилтны сэтгэл ханамжид нөлөөлж буй хүчин зүйлс гэсэн 4 бүлгээр судалгааг 40 ажилтнаас авсан.<br>Судалгааны үр дүнд ажлын ачаалал тэнцвэргүй, тасаг хоорондын уядаа холбоо, мэдээллийн хүртээмж, харилцаа хандлага зэргийг анхаарч ажиллах, бүтээмжийг сайжруулах, ажлын таатай уур амьсгалыг бүрдүүлэх зэрэг ажил зохион байгуулах шаардлагатай байгааг харуулсан. Ажилтан, албан хаагчдын ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж ажлын ачаалал, стресс үүсгэж байгаа асуудал нь 2023 оны 01 сарын 27 өдөр Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх орон тооны бус байнгын комисс томилох тухай шийдвэрээр хэлсийн хэмжээнд 22 зөвлөл, комисс байгуулагдан албан хаагчдыг 2 хүн 11,1 хүн 10, 2 хүн 9, 2 хүн 8, 1 хүн 7, 3 хүн 5, 5 хүн 4, 4 хүн 3, 10 хүн 2, 11 хүн 1 зөвлөл, комиссд байхаар тус тус хуваарилсан нь ажлын ачаалал тэнцвэргүй байхад гол нөлөө үзүүлсэн учраас комиссуудыг нэгтгэн тоог цөөрүүлж, нэг ажилтанд ногдох зөвлөл, комиссын давхардлыг тэнцвэржүүлэх ажлыг зохион байгуулан хэлтсийн хэмжээнд 13 комисстой болж нэг ажилтанг 2-3 комисст хувиарлаж, ачааллыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэнцвэржүүлэн, бүтээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.<br><br><u>Бүтээмж инновацын</u> зөвлөлөөс санаачлан 3 албан хаагч Азийн бүтээмжийн төвийн баталгаажсан мэргэжилтэний сонгон шулгаруулалтанд амжилттай оролцож,<br>➢ ХШДАТ-ийн дарга Г. Галбадрах 2023 оны 06 дугаар сарын 19-23 өдрүүдэд Сингапур улсад “Төрийн үйлчилгээний сайжруулалт” сэдэвт<br>➢ Үйлчилгээний тасгийн дарга Д. Нармандах 2023 оны 07 дугаар сарын 10-14 өдрүүдэд Индонез улсад “Орон нутгийн хөгжилд шинэ мянганы удирдагч нарын оруулж буй аувь нэмэр” сэдэвт<br>➢ Хамралт, орлого шилтгэлийн тасгийн дарга Д. Буянбаяр 2023 оны 11 дүгээр сарын 14-17 өдрүүдэд Бүгд Найрамдах Ардчилсан Лаос ард улсад “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх” сэдэвт сургалтад тус тус зохион байгуулагдаж буй бүтээмжийн мэргэжилтнүүдийн олон улсын хуралд оролцсон.<br>➢ Монголын бүтээмжийн төвийн мэргэжилтэн бэлтгэх сургалтад СДД-ын байцаагч О. Чойенмаа хамрагдаж төгссөн.<br><u>Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр:</u><br>➢ Удирдлагын академийн Төрийн захиргааны сургуулийн Төрийн захиргааны “Ахлах” түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хувийн зарлаар үйлчилгээний тасгийн дарга Д. Нармандах, ХОШТ-ийн дарга Д. Буянбаяр, богино хугацааны мэргэшүүлэх багц сургалтад 3 албан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагч, дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан.<br>Монгол улсыг хөгжүүлэх урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” танхимын сургалтад 4 албан хаагч, цахим сургалтад хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдсан.<br>НД-ын багц хуулийн шинэчлэгдсэн найруулагыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд бүх байцаагч нар чадавхиж хуваарь гарган аймгийн ААНБ, иргэд-даатгуулагч нарт сургалтууд хийж мэдээлэл хүргэн ачааллаа тэнцвэржүүлэн ажиллав.<br>Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан бичил төслийн уралдаанд 4 байцаагч ажилтан, санал хүргүүлсэн.<br>Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /КОЙКА/-аас шинээр хэрэгжүүлэх төслийн санал авч байх хугацаанд 2023 оны 8 дугаар сард “Роботын процессын автоматжуулалт” төслийн санал явуулсан.<br>Боловсрол Шинжлэх Ухааны яамнаас зохион байгуулдаг иргэдийн инноваци саналыг дэмжих Мон-Икс хөтөлбөрт 2 санал хүргүүлсэн боловч 2 дугаар шатанд хасагдсан. | |
| 4.1.6. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах. | | Хэлтсийн ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлаар судалгаа хийх, бүртгэлжүүлэх, тусламж үзүүлэх. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлсэн. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, үр дүнг бүрэн тайлагнасан байна. | Хэлтсийн ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлаар судалгаа хийж, бүртгэлжүүлсэний үндсэн дээр дунд хугацааны хөтөлбөр боловсруулан ажиллаж “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.1-д “Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө”-г жил бүр батлан хэрэгжүүлнэ гэж заасны дагуу оны эхэнд төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. Албан хаагч, ажилтан бүрт зохих журмын дагуу цалинтай болон цалингүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чөлөө өгч, сурч боловсрох нөхцөл боломжоор ханган дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 410.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлж ажилласан байна.<br>5 сараас дээш хугацаатай жирэмсэн албан хаагч болон 0-5 настай хүүхэдтэй албан хаагчдыг тодорхой хугацаанд гэрээс ажиллах нөхцөл боломжоор хангаж, бага насны хүүхэд нь хүндээр өвчилсөн албан хаагчид цалинтай чөлөө олгон ажилласан.<br>2023 оны 6,7 сарууддад Мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд 2 албан хаагчийг, Мэдээллийн технологийн ажилтанг мэргэшүүлэх хөтөлбөрт 1 албан хаагч, Монголын бүтээмжийн төвийн сургалтад 1 албан хаачгийг, Архивын ерөнхий газрын мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагч сургаж чадавхижуулсан.<br>Ахмадын баярын өдрийн тохиолдуулан 22 ахмадад мөнгөн дэмжлэг, хуульд заасан үндэслэлээр 11 ажилтанд түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт олгож, дотоод журамд заасны дагуу шинээр мэндэлсэн 5 хүүхдэд, Засгийн газрын шагнал авсан 2 албан хаагчид тус тус дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>2023 онд ажилтан албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байдал 96% байна.<br>Мөн ЭМСайдын 2017 оны А/472 дугаар тушуулаар батлагдсан шалгуур үзүүлэлтйг бүрэн хангаж “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” -ын гуравдугаар зэрэглэлийг баталсан нь шинэ үзүүлэлт байлаа.<br>Азийн бүтээмжийн төвтэй хамтран 3 албан хаагч Олон улсын сургалтад хамрагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.7. | Хэлтсийн албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | Хэлтсийн албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Хэлтсийн ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 8 удаа зохион байгуулсан. | Ажилтан, албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж хэвшсэн байна. Энэ талын сургалтыг 10 доошгүй удаа сургалт явуулсан байна. | Жилийн турш 23 сурталчилгааны постер бэлтгэж, хөлтэй самбарт хийж, байцаагч ажилчдын ширээн дээр байрлуулах, хэлтсийн албаны вэб хуудас болон пэйж хаягт байрлуулан ажилласан.<br>Мөн авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулахаас гадна хэлтсийн 75776699 дугаарт залгаж, * хэсгээр холбогдох боломжтой болгож, сурталчлан таниулах постерууд бэлтгэсэн.<br>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн албаны пэйж хуудас болон вэб хуудсанд хавсралт 1-ийн постеруудыг байрлуулан нийт 181 хандалт хүлээн авсан байна.<br>Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй томоохон худалдааны төвүүдээр дамжуулан даатгуулагчийн өдөрлөг зохион байгуулж, давхардсан тоогоор 2090 иргэнд нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажилласан.<br>Нийгмийн даатгалын хэлтсийн 1 давхарт Хаан банкны АТМ машины хажууд иргэд ихээр үйлчлүүлдэг газар АВЛИГЫН ЭСРЭГ ХАМТДАА самбар ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.<br>2023 онд дотоод сургалт-5, давхадсан тоогоор 102 хүн хамрагдаж 408 хүн*цаг зарцуулсан.<br>Гадагшаа чиглэсэн сургалт, өдөрлөг нийлээд-18 удаа хийж, 650 гаруй хүн хамрагдаж, 11700 хүн*цаг зарцуулсан байна. | |

*“Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:***

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.1. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 80 удаагийн сургалтад 766 /давхардсан тоогоор/ албан хаагчийг хамруулсан. | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, албан хаагчдын мэдлэг ур чадвар дээшилсэн байна. 2023 онд Сургалтын төлөвлөгөөний дагуу танхим болон цахим хэлбэрээр 50-аас доошгүй удаагийн сургалт зохион байгуулна. | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор цахим болон танхим хэлбэрээр энэ оны байдлаар нийт 50 удаагийн сургалтад 1147 /давхардсан тоогоор/ хүн хамрагдаж 1720 хүн*цаг зарцуулж байцаагч, ажилтнуудыг чадавхжуулсан. | |
| 4.2.2. | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах; | | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | 2022 онд ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 206 удаагийн сургалтад 5934 иргэд, даатгуулагчийг хамруулсан. | 2023 онд нийт 200 дээш удаа Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилсэн байна. | Иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг олгох зорилгоор “Даатгалтай ирээдүй" нийгмийн даатгалын анхан шатны мэдлэг олгох сургалт, Нийгмийн даатгалын тухай хууль, НДСОТТ тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга сурталчлах 136 удаагийн сургалт хийж 4621 даатгуулагч хамруулж 9262хүн*цаг зарцуулсан.<br>Аймгийн засаг даргын орлогч М.Түмэнжаргалын 2023 оны 03 сарын 9-ны өдөр баталсан Мал аж ахуйн хаваржилт, цаг үеийн ажлаар хөдөө явах удирдамжийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдрөөс 2023 оны 03-р сарын 17-ны өдрийг хүртэл 11 чиглэлд нийт 448 өрхөөр орохоос 279 өрхөөр орж 394 иргэнд, нийт 3088 км явж 185 хуудас тараах материал болон мэдээлэл зөвлөгөө хүргэн ажилласан. Мөн малчин тариаланчдын зөвлөгөөнийг Жаргалант суманд зохион байгуулсан бөгөөд уг зөвлөгөөнд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцсон 362 иргэнд мэдээлэл өгч ажилласан. Нийгмийн даатгалын хууль сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөгийг 10 томоохон худалдааны байгууллагууд дээр зохион байгуулж 343 иргэд, даатгуулагчдад мэдээлэл, зөвлөгөө өгч хамруулсан. Баян-Өндөр сумын ЗДТГазраас "Мэдсэнээ хуваалцъя, мэдээлэл хүргэе" өдөрлөг, Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Эрүүл мэндийн өдөрлөг, Хуульчдын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Хуульчдын про боно, Уурхайчин, Баян-Овоот, Чингэл, Жаргалант сумын Жаргалант багуудын нээлттэй хаалганы өдөрлөгүүдэд оролцон Нийгмийн даатгалын хуулийн зөвлөгөө, үйлчилгээг нийт 273 иргэдэд үзүүлэн ажилласан.<br>61 удаагийн явуулын үйлчилгээ, зөвлөгөөнөөр нийт 3393 малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэн, тариаланч нар сургалт болон нийгмийн даатгалын үйлчилгээг газар дээр нь хүргэн ажилласан байна. Хууль сурталчлан таниулах сургалтаар 9262 хүн*цаг зарцуулж ажилласан. | |
| 4.2.3. | Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулахаар орон нутагт зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-нд мэдээлэл байршуулсан тоо, хандалтын тоо Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн тоо, мэдээллийн төрөл 4 байна.<br><br>2022 онд<br>Live 42 удаа<br>Poster 118<br>Short video 3<br>TV 6 | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд шуурхай хүргэсэн байна. | Хэлтсийн фэйсбүүк пэйж хуудас нь 2023 оны байдлаар нийт 19247 дагагчтай болсон. Иргэд, даатгуулагчдад НД-ын хуулийн болон үйлчилгээний талаарх мэдээллийг ойлгомжтой хүртээмжтэй хүргэх зорилгоор богино хэмжээний бичлэг хийж хүргэдэг. Пэйж хуудсандаа энэ оны байдлаар 11 удаагийн бичлэг байршуулсан. Нийт хандалтын тоо нь 122678. Хэлтсийн цахим хуудсаар дамжуулан иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын 5 сангийн хүрээнд мэдээлэл хүргэн 36 удаагийн шууд лайв хийж 78398 хандалттай. Уг үйл ажиллагааг улам хэвшимэл болгох, засан залруулах, дээшлүүлэх үүднээс шууд бичлэгийн өмнө постер байршуулдаг болсон. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, даатгуулагчид, ажил олгогчид мэдээлэл түгээхээр зохион байгуулсан арга хэмжээний төрөл, сурталчилгаа хийсэн тоо<br>Зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл | | 2023 онд<br>Live 50 удаа<br>Poster 120<br>Short video 5<br>TV 6<br>Хүргэж ажиллана. | үүнтэй холбоотой сайн дурын даатгалын дүн өөрчлөгдсөн талаарх, Нас барсан иргэний тэтгэврийн 20%- ийг эхнэр эсвэл нөхөрт нь өвлүүлэх тухай, Хөдөлмөрийн чавдар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт цахимаар илгээх тухай, Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагын тухай, АО байгууллагын эрх үүргийн тухай, Нийгмийн даатгалын хэлтсийн дэвтэр 2020 оноос цахимд шилжсэн тухай мэдээллүүдийг бэлтгэн Номин ТВ, Тусгал ТВ, ETV HD телевизүүдийг эх сурвалжаар хангаж 12 удаагийн давтамжтай нэвтрүүлэг бэлтгэн пэйж хуудсанд байршуулж Орхон аймгийн иргэдэд хүргэн 67523 хандалт авсан. Нийт 161 шинээр постер бэлтгэн НДХ-ийн болон орон нутгийн хандалт ихтэй группт түгээсэн. | |
| *“Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.3.1. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангаң ажиллах | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч нар нь үечилсэн дүгнэлтэд жилд 2-оос доошгүй удаа үнэлгээ хийсэн байна. | Өрхийн 9 эмнэлэгийн ахлагч болон эмч нарт 3 удаагийн сургалт зохион байгуулсан. 2022 онд хагас бүтэн жилээр 2 удаа тайланг гаргаж ЭХМТК-т хүргүүлсэн байна. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч нар нь үечилсэн дүгнэлтэд үнэлгээ хийж эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар хэлэлцүүлсэн үечилсэн дүгнэлтийн 30-аас доошгүй хувийг хамруулсан байна. | 2023 онд ЭХМТөв Комиссоос салбар комиссуудтай сайн хамтарч ажилласан ба Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийг 2016 оноос хойш дахин шинэчлэн Засгийн газрын тогтоолоор 2021 оны 03-р сарын 17-нд батлан мөрдөн ажиллуулж эхэлсэн.Түүнчлэн 2021 оны 03-р сарын 10-нд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/38 тоот тушаалаар Эмнэлгийн хуудас бичилт, олголт, хяналт тавих журам шинэчлэн батлагдан хэрэгжүүлж эхэллээ.Ингэснээр шинэ журам болон дүрэм хэрэгжүүлэх хэвшүүлэх зорилгоор өрхийн 9 эмнэлгийн ахлагч болон эмч нар мөн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтнүүд, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмч нарт дээрх чиглэлээр 2023 онд 2 удаагийн сургалт зохион байгууллаа.Учир нь өрхийн эрүүл мэндийн төв болон хувийн | |
| | | | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлж буй | | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлж буй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна. | | иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна. | хэвшлийн эмнэлэгүүдийн эмч боловсон хүчний шилжилт хөдөлгөөн их байгаа нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой алдаа дутагдал давтагдахаас сэргийллээ. Дээрхи хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа дутагдлыг цаг тухайд нь засаж залруулах талаар утсаар болон биеэр зөвлөгөө заавар өгч давтан зөрчилтэй 4 эмнэлгийн байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажиллаа.<br>Манай нийгмийн даатгалын хэлтэсээс 2023 онд УИХ-аар НД-ын багц хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотой сургалт сурталчилгааг аймгийн 2300 ААН-д хийснээс магадлагч эмч 15 байгууллага 300 албан хаагчид хичээл зааж Эмнэлэг хөдөлмөрийн магадлал, тэтгэвэр тэтгэмжийн талаар 36 удаагийн шууд нэвтрүүлэгт 26 байцаагч оролцож НД-ын пэйж хуудсандаа байршуулсаныг 79398 хүн шууд үзжээ.Нийт шууд нэвтрүүлэгтээ ЭХМК болон эрүүл мэндийн талаархи мэдээллээ байнга оруулдаг . | |
| | | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хагас жил тутам тулгалт хийсэн байна. | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд тулгалт хийж цахим мэдээллийн санг бүрдүүлсэн байна. | | |
| 4.3.2. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг хагас жил тутам зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭХМТК-т хүргүүлсэн байна. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Эмнэлэг хяналтын комисс, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссыг нэг өдөр нэг цагийн зөрүүтэй нэг газар 2 өөр танхимд хуралддаг байхаар зохион байгуулсан бөгөөд хурлаар ХЧА-ын хувь хугацаа тогтоох иргэдэд үйлчлүүлэх ЦАХИМ цаг олгож дараалал хүлээн суухгүйгээр өөрийн цагийн хуваарьт үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлж иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж энэ нь бүрэн хэвшлээ. Мөн хурлын үеэр иргэдийг НДХ, ХХҮГ, банк зэрэг байгууллага руу явуулахгүйн тулд дээрхи байгууллагуудын мэргэжилтэнүүд ирж холбогдох үйлчилгээг газар дээр нь хийж гүйцэтгэж байна.COVID-19-төй холбоотойгоор 2022 онд ЭХМК болон ЭХК- | |
| | | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна | | дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадвар сайжирч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа ижил түвшинд хүрсэн байна. | ийн хурал цахим хэлбэрээр хуралдаж байсан ба 2023 онд ЦАХИМ, БИЧИГ БАРИМТ, БИЕЭР гэсэн 3 хэлбэрээр хуралдаж хурлын явц, ирц бүрийг камераар бичиж баталгаажуулан ЭХМТКомисс руу илгээдэг боллоо. 2023 оны эхний улиралд Эрүүл мэндийг дэмжих төвд “Эрт илрүүлэг, Урьдчилан сэргийлэлэх үзлэг” иргэдэд хийгдэж ачаалал ихтэй байсан ч 2 комисс хурлаа тасалдуулахгүйгээр, иргэдэд чирэгдэл үүсгэхгүйгээр зохион байгуулж байна.<br><br>ЭХК болон ЭХМК-ын хурлын заалууд , иргэн /даатгуулагч/-дын хүлээлгийн танхим, бие засах өрөө, ӨЭМТ-ийн эмч нарын өрөө зэрэг нь эрүүл ахуй, стандарт шаардлага хангасан тохижолттой орчин бүрдүүлсэн нь иргэдийн талархлыг хүлээж байна.<br>2022 онд ЭХК болон ЭХМК-ын иргэн /даатгуулагч/-ийн өвчний онош, хувь, хугацааны зөрүүтэй тохиолдол 13 байсан бол 2023 оны эхнийхагас жилд 2 комиссын хамтарсан 2 удаагийн уулзалт 1 удаагийн сургалтын үр дүнд дээрхи тохиолдол бүртгэгдээгүй байна.Иргэдийг чилээхгүй , чирэгдүүлэхгүй байх үүднээс нэвтрүүлсэн ЦАХИМ цаг авалтын системийг Эмнэлэг хяналтын комисст нэвтрүүлэхээр одоогоор ажиллаж байна.<br>Энэ туршлага нь Монгол улсын хэмжээнд бүх ЭХМК-дад нэвтэрч хэрэгжүүлж байна.<br><br>Мөн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын файлыг шууд баталгаажуулдаг болсноор ХХҮГ-ын халамжийн сангаас тэтгэмж авдаг иргэн /даатгуулагч/-ын мэдээллийг нэг өдрийн дотор дамжуулдаг болсон. | |
| | | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд сайн туршлага нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд сайн туршлага нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж туршлага солилцсон байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2023 онд ЭХМК нь нийт 46 удаа хуралдаж нийт 3145 иргэний ХЧА-ын асуудлыг шийдвэрлэсэн байна. Үүнд:<br>➢ Хөдөлмөрийн нөхцөл сольсон 6<br>➢ ХЧТА-ын хувийг нэмэгдүүлж сунгасан-297<br>➢ ХЧТА-ын хувийг бууруулж сунгасан – 307<br>➢ ХЧТА-ын хувийг хэвээр сунгасан - 1689<br>➢ ХЧТА-ын хувь, хугацааг цуцалсан - 234<br>➢ Шинээр ХЧА-ын хувь тогтоосон -330<br>➢ Шилжиж ирсэн -13<br>➢ Шилжиж явсан -18<br>➢ Тайлант хугацаанд ХЧА иргэн нас барсан – 109<br>2023 онд ЦАХИМ, БИЧИГ БАРИМТ, БИЕЭР гэсэн 3 хэлбэрээр хуралдаж ХЧА-ын хувь, хугацаа тогтоолгох, сунгуулах иргэдийн өвчтөний онош бодит байдалтай хэрхэн нийцэж байгааг өвчтөний багажийн шинжилгээ мөн ХЧА-ын хувь, хугацаа тогтоох жагсаалттай тохирч байгаа эсэхэд хяналтыг сайтар хийн ажиллаж байна. 3145 иргэн даатгуулагч орсноос 2953 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан байна. Судалгааны дүнд анализ хийж ажилласнаар нэг иргэний хуралд орох хүлээлгийн хугацаа 30-60 минут байна.<br><br>Иргэдийн санал хүсэлтийг үндэслэн 2023 оны 2 дугаар улиралд аймгийн засаг дарга Эмнэлэг хяналт болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын үйл ажиллагаатай биечлэн танилцаж тулгамдсан асуудлыг судлан шийдвэрлэхээр боллоо.<br>Үүнд:<br>1.Хурлын хүлээлгийн танхимын сандал<br>2.Иргэн /даатгуулагчид/-ын гадуур хувцасны өлгүүр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3.Иргэдэд үйлчлэх шүүлтүүр бүхий ус буцалгагч | |
| 4.3.3. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэх | | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллана. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн болон судалгааны тайланг ЭХМТК-т хүргүүлнэ. | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсэн байна. | Өрхийн 9 эмнэлгийн ахлагч , Жаргалант сумын болон эмч нар мөн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн эмч нарт дээрх чиглэлээр 2021 оны 3-р сард батлагдсан Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийн шинэчлэл, 2021 оны 5 сард батлагдсан эмнэлгийн хуудас бичих журмын талаар 2023 онд 3 удаа сургалт зохион байгуулпаа. Нийгмийн даатгалын хэлтсээс 12 аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт явууллаа. Хөдөлмөрийн чадвар алдалтыг урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор Магадлагч эмч нь аймгийн Хөдөлмөрийн Аюулгүй байдал Эрүүл ахуйн зөвлөлд байдаг бөгөөд уг комисс нь “Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулъя – ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлье” уриан дор хууль тогтоомжийг сурталчилах, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажлын байрны соёлыг төлөвшүүлэх, сургалт, сурталчилгааг өрнүүлэх зорилтын хүрээнд Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ачит-Ихт ХХК-тай хамтран 2 удаагийн сургалтанд суулаа.Энэ зөвлөл нь 2023 оны үйл ажлаараа аймагт тэргүүн байр эзэлсэн.ЭХМК-ийн гишүүд нь улсын зөвлөгөөн болон бусад цахим сургалтаар авлигын эсрэг хичээлд бүрэн хамрагддаг ба хуралд эрх | |
| | | | Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаа хийж, тодорхой арга хэмжээ авч орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагад танилцуулсан байна. | | Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаатай болсон байна. | | |
| | | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлж Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссыг хурлын байраар хангах, тохижуулах ажлыг холбогдох байгууллагад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уламжлан шийдвэрлүүлэх, сургалт сурталчилгаа хийх нөхцөлийг бүрдүүлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх тоног төхөөрөмжөөр хангах зэрэг ажлыг зохион байгуулсан байна. | ашгийн зөрчил гаргахгүй байх талаар гарын үсэг зурж ордог.<br><br>Орон нутгийн дэмжлэгээр хурлын хүлээлгийн танхимд<br>➢ Ус шүүгч<br>➢ 20 ширхэг сандал<br>➢ 3 ширхэг хувцасны өлгүүр тавьж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хурлын хүлээлгийн үед тав тухтай байх орчиныг бүрдүүллээ. | |
| 4.3.4. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаарх хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | 2022 онд 13 аж ахуй нэгжид ҮОМШӨ-с урьдчилсан сэргийлэх сургалт зохион байгуулсан. “Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулъя – ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлье” уриан доор 3 хоногийн сургалт | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын болон Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, төрөлжсөн мэргэжлийн, сумын, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн чиглэлээр сургалт зохион байгуулж шинэ мэдээ, мэдээллийг хүргүүлж ажилласан байна. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын гишүүд 2023 онд Авлига ашиг, сонирхолын зөрчилгүй оролцохоо баталж гарын үсэг зурж баталгаажууллаа.<br><br>Мөн ажлын байранд авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны гарын авлагатай танилцаж өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, мөрдлөг болгон ажиллаж байна.<br><br>Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс 2023 оны 05 сарын 25-ны өдөр Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэг удаагийн сургалт авч ажиллалаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, төрөлжсөн мэргэжлийн, сумын, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | семинар зохион байгуулсан. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын болон Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, төрөлжсөн мэргэжлийн, сумын, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан байна. | | |
| *“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.4.1. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, даатгуулагчийн мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хангах | | Тухайн онд идэвхтэй шимтгэл төлөгч даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн регистрийн дугаартай 100% нийцсэн байна. | 2022 онд даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн сантай 99.92% нийцсэн. | Нийт даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн регистрийн дугаартай нийцсэн байна. | Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийгмийн даатгалд бүртгэлтэй 3127 ажил олгогчоос бүртгэлтэй идэвхэй тайлан ирүүлсэн 1425 аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн улсын бүртгэлийн нэгдсэн сан http://opendata.burtgel.gov.mn/les мэдээллийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тухайн онд идэвхтэй шимтгэл төлөгч даатгуулагчийн овог /эцэг, эхийн нэр/ улсын бүртгэлийн мэдээллийн овог /эцэг, эхийн нэр/-той 100% нийцсэн байна. | 2022 онд даатгуулагчийн овог /эцэг, эхийн нэр/ улсын бүртгэлийн мэдээллийн сантай 99.62% нийцсэн. | Нийт даатгуулагчийн овог /эцэг, эхийн нэр/ улсын бүртгэлийн мэдээллийн овог /эцэг, эхийн нэр/-тэй нийцсэн байна. | баазтай тулган шалгаж ажиллаж байна. Мэдээллийн санд бүртгэлтэй 33247 даатгуулагчийн мэдээллийг улсын бүртгэлийн http://10.9.0.5/regweb/#/account/login программтай тулган шалгаж 32 даатгуулагчийн регистрийг засварлаж, 24 даатгуулагчийн регистр нэгтгэсэн байна.<br><br>НДЕГ-аас ирүүлсэн 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01/1883 тоот бичгийн дагуу нийгмийн даатгалын мэдээллийн ситемийг цогцоор нь шинэчилж 2024 оны 01дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэхтэй уялдуулан 344 гадаад иргэний мэдээллийг гадаадын иргэн, харъяатын газраас олгосон 13 оронтой тоогоор шинэчлэн судалгаг хийж бүртгэн ажилласан байна. | |
| | | | Тухайн онд идэвхтэй шимтгэл төлөгч даатгуулагчийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн нэртэй 100% нийцсэн байна. | 2022 онд даатгуулагчийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн нэртэй 99.95% нийцсэн. | Нийт даатгуулагчийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн нэртэй нийцсэн байна. | | |
| | | | Өмнөх онуудад шимтгэл төлж байсан даатгуулагчдын овог, нэр, регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн сантай 95% нийцсэн байна. | | Өмнө онуудад шимтгэл төлж байсан даатгуулагчийн мэдээлэл улсын бүртгэлийн мэдээлэлтэй нийцсэн байх | | |
| 4.4.2. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байна. | 2022 онд ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.92% байсан. | Ажил олгогчийн үндсэн мэдээлэл буюу ЭЗҮАСА, өмчийн болон хариуцлагын хэлбэр, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | Нийгмийн даатгалд шинээр хамруулсан ажил олгогчийн мэдээллийг бүрдүүлэн авч өмчийн хэлбэр, татварын бүртгэлийг бүрэн гүйцэд бүртгэж ҮОМШӨ-ний даатгалын хувь хэмжээг өөрчлөлтийг хийж ажилласан. | |
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн | | -Даатгуулагчийн үндсэн мэдээллийг зөв | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийг үнэн зөв бүрдүүлсэн байна. | | хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн төрлийг зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн улсын кодыг зөв хүлээн авсан байна.<br>- Тухайн ажил олгогч дээр нэг сар дээр нэг даатгуулагчийг нэгээс илүүгүйгээр тайланд тусгуулсан байна. | | |
| | | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байна. | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байна | | |
| 4.4.3. | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгээгүй байна. | Тус онд давхардсан тоогоор 16656 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг http://10.9.11.2:808/ndlav/ программд тулган шалгалт хийж давхардсан эсэхийг хянан шалгаж баталгаажуулан ажиллалаа. | |
| | | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгээгүй байна. | Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хүлээн авч 4291 даатгуулагчийн сайн дурын даатгуулагчийн бодолтыг хийж шалган аж ахуйн нэгж байгууллагаас цалин олгогдсон сайн дурыг даатгуулагчийн төлөлтийг дараа сарын | |
| | | | Сайн дурын даатгуулагчийн | | Сайн дурын даатгуулагчийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | | ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийгээгүй байна. | нийгмийн даатгалын шимтгэлд тооцуулан ажиллаж байна.<br>Цахим хяналтын программ http://10.9.0.5/monitoring/WrongReport.aspx/ хангамжтай тулган гарсан зөрчлийг тухай бүрт нь залруулж 146 ажил олгогчтой холбоотой мэдээлэлд төрлийн болон цалингийн залруулга хийн ажиллалаа. | |
| | | | Цахим хяналтын програм хангамжаар илэрч буй алдааг 100% нягталж залруулсан байна. | | Цахим хяналтын програм хангамжаар илэрч буй алдааг 100% нягталж залруулсан байна. | | |
| 4.4.4. | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна. | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамжийн үйл ажиллагаа хэвийн явагдсан. | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамж, серверийн найдвартай ажиллагааг хангаж гэмтэл, саатал гарсан тохиолдолд түргэн шуурхай илрүүлж хэвийн ажиллагааг хангах арга хэмжээг авсан байна. | Тайлант хугацаанд дотоод сүлжээний шинэчлэл бүрэн явагдаж дууссан. Нийт 8 албан хаагчийн сүлжээний толгой буюу RJ45 муудсанг сольж шинэчилсэн. Бүх хэрэглэгчийн сүлжээний толгойг СВИЧ дээр нь кодлож дуусгасан. Ингэснээр тухайн хэрэглэгч дээр сүлжээний асуудал үүсэхэд цаг алдалгүй оношлох болно. Хэлтсийн техник хангамжийн хувьд тухай бүр нь асуудлыг шийдэн ажиллаж байна.<br>11 принтерийг бусад хэрэглэгчид таниулсан. Цаашид принтерийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай судалгааг гаргаж хүргүүлсэн.<br>Байцаагч ажилтнуудын программ болон техник ашиглах чадварыг өсгөхийн тулд нэг бүрчлэн ашиглаж буй техник болон программ хангамжийн ашиглалтын талаар дэлгэрэнгүй зөвлөгөө өгч ажиллаж байна.<br>Бүх албан хаагчдад тухайн ашиглаж буй төхөөрөмжийн бүртгэлийг 100% хийж бүх үзүүлэлт IP хаяг “Call Center” IP утасны мэдээллийг бүртгэж авсан.<br>МТТөвөө ирсэн программын шинэчлэл ирсэнг байцаагч ажилтнуудад суулгаж зааврыг өгч ажилласан. Калл центрийн дуудлагын бүртгэлийг өдөр өдрөөр нь гаргаж өгч хэвийн горимд ажиллаж байна. Шинээр ажлын бус | |
| | | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж буй байдал, нэгжид ашиглагдаж буй програм хангамжуудын шинэчлэлт өөрчлөлт цаг хугацаандаа хийгдсэн байна. | Нэгжид ашиглагдаж буй програм хангамжууды н шинэчлэлт, өөрчлөлтийг цаг хугацаанд нь хийсэн. | Нэгжид ашиглагдаж буй програм хангамжуудын шинэчлэлт, өөрчлөлтийг цаг тухайд нь хийж байцаагч ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | | |
| | | | МТТ-өөс батлан мөрдүүлж буй “Сервер | Оны эцсийн үйлчилгээний журмын | Нэгжийн сервер компьютерийн оны эцсийн тохируулга | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | компьютерийн оны эцсийн үйлчилгээний журам"-ыг хэрэгжүүлсэн байна. | хэрэгжилт хангагдсан. | үйлчилгээг журмын дагуу бүрэн хийж тайланг цаг хугацаанд нь баталгаажуулан МТТ-д ирүүлсэн байна. | цагуудад дуудлага хүлээж авахгүй байхаар тохируулсан. Байцаагч ажилтнуудын утасны бүртгэлийг болиулах сэргээх зэрэг ажлыг тухай бүр нь хийж байна. Серверийн хард дүүрч байсныг цэвэрлэж вирус уншуулсан.<br>Оны эцсийн үйлчилгээг журамд заасны дагуу хийж гүйцэтгэж тайланг МТТ – д хүргүүлсэн болно. МТТ – өөс ирсэн албан бичгийг цаг тухайд нь хариу судалгааг авч явуулж байна. Мөн шинээр орсон албан хаагчдад тухай бүр нь программын эрх нээлгэх тухай албан тоотыг өгч ажилласан.<br><br>Калл центрийн үйлчилгээнд дуудлага алдагдал гаргахгүйн тулд хувийн утаснуудыг холбож өгсөн. Авлигын тухай мэдээлэх * товч нэмсэн. | |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байна. | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | | |
| **Тав.Нэмэлт ажил үйлчилгээ** | | | | | | | |
| 5.1 | ISO 37001 Авлигын эсрэг үйл ажиллагааны олон улсын стандарт хэрэгжүүлэх нэвтрүүлэх | ҮА-ны зардал болон НДЕГ-ын төсөв | Хэрэгжүүлсэн байх<br><br>баталгаажуулсан байх | ISO 9001:2015 Чанарын удирдлагын стандарт | 2022 онд бүрэн нэвтрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын байгууллагын менежментийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийг эрсдлээс хамгаалах, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, төрийн байгууллагад авлига бий болох шалтгаан нөхцөлийг арилгах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, хариуцлагыг чангатгах, шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор олон улсын ISO 37001:2016 стандартад нийцсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг тус хэлтэс 2022 оноос эхлэн үе шаттайгаар, холбогдох стандартаар тогтоосон шаардлагын дагуу нэвтрүүлэн ажиллаж Монгол Улсын Төрийн байгууллага дундаа анх удаа хэрэгжүүлж 2023 онд Авлигын эсрэг ISO 37001:2016 стандартад нэвтрүүлж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | БНЭУ-ын олон улсын баталгаажуулалтын QFC байгууллагын батламж гэгчилгээг БНЭУ-ын Элчин сайдаас гардан авсан. | |
| 5.2 | Ухаалаг архивын системийг НДХ-ийн “үндсэн” архивт бүрэн нэвтрүүлэх | Орон нутгийн төсөв | Нэвтрүүлсэн байх | 2022 онд Тэтгэврийн архивт бүрэн нэвтрүүлсэн. | 2023 онд Үндэс архивын 14 мянган баримтыг цахимжуулсан байна. | Нийгмийн даатгалын нэгдсэн архивт хадгалагдаж байгаа байнгын болон НДШ-ийн баримт тус бүр дээр, ТҮР болон 70 жил хадгалагдах баримтын хайрцаг тус бүр дээр нийт 8859 ширхэг бар код шошго нааж системд бүртгэн цахимжуулсан. | |
| 5.3 | Хэлтсийн ойр орчмын эзэмшил газрын ногоон байгууламжийг сайжруулах, шинээр мод тарих арга хэмжээ авч ажиллах | ҮА-ны зардал | Шинээр тарьж ургуулсан модны тоо, ногоон байгууламжийг сэргээн засварлаж арчилгаа тордолгоо хийсэн тоо, чанар | 2022 онд 20ш чацарганы мод, 30ш шар хуайс шинээр тарьж ургуулсан. | Хэлтсийн ногоон байгууламжинд 30-аас доошгүй мод бут шинээр тарьж ургуулсан байна.<br><br>Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгууллагын хэмжээнд 2-оос доошгүй үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна. | Тэрбум мод үндэсний хөтөлбөр, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн зорилт арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын хэлтэс нь нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэх, түүний арчилгаа хамгаалалтыг сайжруулах, хэлтсийн ойр орчмын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор шар хуайс 30ш, чацаргана 20ш гэх мэт мод бут сөөгийг шинээр тарьж ургуулах шинээр хайс, хашлага барих сэлбэн засах ажиллуудыг хийж, арчилгаа тордолгоог тогтмол хийж байна.<br><br>Мөн төрийн байгууллагуудын оролцоотойгоор Сархиа уулын энгэрт 20ш мод , Тарлан толгой уулын энгэрт 30 ширхэг айлаас мод тарьсан. | |
| 5.4 | Хэлтсийн хог, хаягдлыг зөв менежментээр шийдвэрлэх | ҮА-ны зардал | Хог, хаягдлыг ангилан ялгадаг болсон байна. | 2023 онд шинээр хэрэгжүүлнэ. | Цаасан хог хаягдалыг ангилан ялгаж зориулалтын | Нийгмийн даатгалын хэлтсийн байранд цаас болон бусад хог хаягдал гэсэн зориулалтын 2 сав бэлтгэн цаасан хогоо ангилан ялгаж байна. Цаасан хог хаягдал боловсруулах Аж ахуй нэгж байгууллагад сар бүрийн тогтсон өдөр хүлээлгэн өгч байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газарт өгдөг болсон байна. | Мөн хэлтсийн гадна үүдний хэсэгт хуванцар сав ангилан ялгах сав бэлтгэн байршуулан ангилан ялгаж байна.<br>Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх бүх төрлийн зай буюу батарейг ангилан 1ш сав бэлтгэсэн.<br>Хэлтсийн Нууцын ажилтанаар хянуулсан, нууцад үл хамаарах мэдээлэл бүхий цаасны хаягдлыг шахмал түлшний үйлдвэрт өгч хэвшлээ. | |
| 5.5 | Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбогдуулан байгууллагын архив, албан хэрэг хөтлөх үйл ажиллагаанд урьдчилсан болон давтан үзлэг зохион байгуулах, ААХХ-ийн улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах | ҮА-ны зардал | Үзлэг зохион байгуулсан тоо, бэлтгэл ажлыг хангасан байдал | 2023 онд шинээр хэрэгжүүлнэ. | Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа сайжирч Архивын улсын үзлэгт 90-ээс дээш хувьтай үнэлүүлнэ. | Тус хэлтсийн БНШК, Хяналт, шалгалт дотоод аудитын тасгаас архивын улсын үзлэгтэй холбогдуулан байгууллагын архив, албан хэрэг хөтлөх үйл ажиллагаанд урьдчилсан үзлэг зохион байгуулах удирдамж боловсруулан батлуулан ажилласан.<br>Удирдамжын дагуу үзлэг хийгдэж улсыг үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулан зөрчлийн арилгуулан ажиллаж байна.<br>Мөн Хэлтсийн даргын удирдамжийн дагуу дотоодын хяналт шалгалт хийлээ. | |
| 5.6 | Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийг нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд хамруулж орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх ажлыг зохион байгуулна. | Орон нутгийн төсөв | Нийгмийн даатгалын болон , эрүүл мэндийн хамруулсан эцэг эхчүүдийн тоо, зарцуулсан мөнгөн дүн | 2022 онд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэрээр асарч байгаа 88 эцэг эхчүүдийг нийгмийн даатгуулд хамруулсан. | Хүнд хэлбэрий хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэрээр асарч байгаа 95 эцэг эхчүүдэд нийгмийн даатгалын шимтгэл 121.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж хамруулна. | Орхон аймгийн Засаг даргын 2023 оны А/114 дүгээр захирамжийн дагуу “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эхчүүд”-ийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Засаг даргын Төсөл хөтөлбөрийн зардлаас хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 104 эцэг эхчүүдийг сайн дурын даатгалд хамруулж 114.3 сая төгрөгийн шимтгэл, 96 хүнийг эрүүл мэндийн даатгалд хамруулж 6.7 сая төгрөгийн шимтгэл нийт 120.9 сая төгрөгийн шимтгэлийг шимлжүүлэн хамрагдалтыг нэмэгдүүлэн ажилласан. Иргэдийн мэдээллийг тухай бүрт нийгмийн даатгалын нэгдсэн системд оруулан даатгуулагчид мэдээлэл зөвлөгөөг хүргэн ажилласан. | |

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Д.НАРМАНДАХ/